



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Боловсролын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:  
[boldbaatarkhu@audit.gov.mn](mailto:boldbaatarkhu@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:  
[tsetsegsurena@audit.gov.mn](mailto:tsetsegsurena@audit.gov.mn)

Аудитор: Н.Ариунтуяа

Утас: 70432545

Цахим хаяг: [ariuntuyan@audit.gov.mn](mailto:ariuntuyan@audit.gov.mn)

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр).....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	10
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага .....	11
3.3 Зөвлөмж .....	11
3.3.1 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олголттой холбоотой асуудал .....	11
3.3.2 Анхан шатны баримтын иж бүрдэлтэй холбоотой асуудал .....	12
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	13
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБООУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
УСНБООУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт Боловсролын ерөнхий газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.24 № 131  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.АЛТАНТУНГАЛАГ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Боловсролын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр "Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл" хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3 дахь хэсгүүд болон Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтуудтай нийцээгүй, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 2-д тэтгэмжид тавигдах шаардлагад багш, ажилтан төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д томилогдсон өдрөөс хойш тасралтгүй таван жил (60 сар) болон дараагийн гурав дахь жил (36 сар) ажилласан байна гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийг журамд заасан хугацааг баримтлаагүй 265,122.0 мянган төгрөгийг олгосон,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигддэг сургалтын зардлын гүйцэтгэлийн тайлан тооцоогүй, төсөв төлөвлөгөө, сургалтын тайлан, ирцийн

8426050278

бүртгэл байхгүй, үр дүнг үнэлээгүй, анхан шатны санхүүгийн баримтын бүрдүүлэлт хангалтгүй,

- Үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцон олгосон ч тус урамшуулалтай давхардуулан тушаал шийдвэргүй 1,241.7 мянган төгрөг олгосон;
- Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн нэмэгдлийг холбогдох үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэхгүйгээр хавтгайруулан олгосон;

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын газар нь Монгол Улсын ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамруулахаар 103 суралцагчийн мэдээллийг урьдчилсан байдлаар хянаж хүргүүлснээс 14 хүүхэд ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Ерөнхий боловсролын сургуулийн дунд ахлах ангийн багш нарт академик болон заах арга зүйн сургалтыг судлагдахуун тус бүрээр ментор багш урьж үе шаттайгаар зохион байгуулан ерөнхий боловсролын сургуулийн 1051 багш хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилго 12 хөтөлбөр, 24 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг тайлагнан дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,413,865.00</b>	<b>18,284,400.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	125,865.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,288,000.00	18,284,400.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	0.00	1,429,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	1,429,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,146,236.06	233,852,889.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	45,087,826.06	218,383,279.16
35110	Тусгай зориулалттай материал	45,087,826.06	218,383,279.16
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,058,410.00	15,469,610.00
35410	Бичиг хэргийн материал	525,000.00	175,000.00
35420	Аж ахуйн материал	4,850,720.00	2,763,720.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,990,000.00
35470	Бусад хангамжийн материал	9,682,690.00	10,540,890.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	3,542,098.55	0.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	3,542,098.55	0.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66,102,199.61</b>	<b>253,566,289.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	329,113,272.48	235,207,095.09
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	304,813,272.48	210,907,095.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,963,100.00	3,963,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-660,516.48	-770,602.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	444,799,662.08	423,835,062.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-193,368,343.65	-248,558,558.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,358,496.76	62,358,496.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,525,207.18	-29,920,402.46
39217	Ном	11,246,080.95	0.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	24,300,000.00	24,300,000.00
39301	Програм хангамж	2,125,000.00	2,125,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,125,000.00	-2,125,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,300,000.00	24,300,000.00
<b>394</b>	<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>	0.00	0.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>329,113,272.48</b>	<b>235,207,095.09</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>395,215,472.09</b>	<b>488,773,384.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	395,215,472.09	488,773,384.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,988,494.00	258,988,494.00
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	258,988,494.00	258,988,494.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	131,710,526.80	225,268,438.96
51210	Өмнөх үеийн үр дүн	58,181,543.43	131,710,526.80
51220	Тайлант үеийн үр дүн	73,528,983.37	93,557,912.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,516,451.29	4,516,451.29
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>395,215,472.09</b>	<b>488,773,384.25</b>

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>395,215,472.09</b>	<b>488,773,384.25</b>
---	--	-----------------------	-----------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>10,299,247,036.00</b>	<b>8,080,092,304.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	8,675,137,500.00	6,732,556,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,675,137,500.00	6,732,556,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,624,109,536.00	1,347,535,604.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,578,125,500.00	1,267,210,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,984,036.00	80,325,500.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>517,926,345.32</b>	<b>195,823,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	517,926,345.32	195,823,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	474,341,723.16	4,015,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	43,584,622.16	191,808,000.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,817,173,381.32</b>	<b>8,275,915,704.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,305,955,682.33</b>	<b>8,145,076,803.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,303,567,518.33	1,591,806,147.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	586,295,674.78	791,062,075.77
210101	Үндсэн цалин	369,913,109.78	486,547,319.77
210102	Нэмэгдэл	141,318,195.00	197,286,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,810,000.00	55,190,000.00
210104	Урамшуулал	41,254,370.00	52,038,456.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	73,215,128.22	105,914,886.23
210201	Тэтгэврийн даатгал	49,896,132.11	73,758,858.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,759,484.91	7,956,615.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,116,886.45	4,286,789.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,718,407.04	3,978,863.73
210205	Эрүүл мэндийн даатгал	11,724,217.71	15,933,758.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,532,036.00	25,998,842.00
210301	Гэрэл, цахилгаан	1,711,196.00	4,113,872.00
210302	Түлш, халаалт	13,010,830.00	15,623,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,810,010.00	6,261,370.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,893,450.00	40,067,380.00
210401	Бичиг хэрэг	13,863,750.00	21,640,000.00

210402	Тээвэр, шатахуун	11,663,950.00	10,694,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,200.00	804,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,161,550.00	6,929,180.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	30,360,000.00
210502	Хоол, хүнс	0.00	30,360,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,040,000.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	3,040,000.00	600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	158,000.00	22,183,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,000.00	22,150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,596,433,229.33	575,619,963.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,583,970.00	60,835,572.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,539,807,800.00	438,517,229.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,041,459.33	76,267,161.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,002,388,164.00	6,553,270,656.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,556,080,338.00	6,372,534,230.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,710,100,338.00	1,582,041,230.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,845,680,000.00	4,032,378,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	758,115,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	446,307,826.00	180,736,426.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,158,480.00	180,736,426.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>10,305,955,682.33</b>	<b>8,145,076,803.39</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>511,217,698.99</u></b>	<b><u>130,838,900.61</u></b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	145,404,446.62	21,654,415.45
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	292,284,269.00	15,626,573.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	437,688,715.62	37,280,988.45
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-437,688,715.62	-37,280,988.45
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>73,528,983.37</u></b>	<b><u>93,557,912.16</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	58,181,543.43	321,686,488.7

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	58,181,543.43	321,686,488.7
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	73,528,983.37	73,528,983.37
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	131,710,526.80	395,215,472.1
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	131,710,526.80	395,215,472.1
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	131,710,526.80	395,215,472.1
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	93,557,912.16	93,557,912.2
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	225,268,438.96	488,773,384.2

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,299,247,036.00</b>	<b>8,082,380,304.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	8,675,137,500.00	6,732,556,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,675,137,500.00	6,732,556,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,624,109,536.00	1,349,823,604.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,578,125,500.00	1,267,210,104.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,984,036.00	82,613,500.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>10,299,247,036.00</b>	<b>8,082,380,304.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,259,089,458.00</b>	<b>8,082,380,304.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,254,413,294.00</b>	<b>1,510,825,248.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	563,532,921.00	790,924,439.00
210101	Үндсэн цалин	320,011,365.00	409,360,335.00
210102	Нэмэгдэл	166,878,971.00	277,059,900.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,760,000.00	54,487,727.00
210104	Урамшуулал	42,882,585.00	50,016,476.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	96,103,747.00	105,926,658.00
210201	Тэтгэврийн даатгал	73,455,247.00	72,886,358.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,662,100.00	8,260,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,831,100.00	4,130,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,831,100.00	4,130,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,324,200.00	16,520,000.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,250,676.00	25,998,842.00
210301	Гэрэл, цахилгаан	1,711,196.00	4,113,872.00
210302	Түлш, халаалт	13,729,470.00	15,623,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,810,010.00	6,261,370.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,965,400.00	17,964,930.00
210401	Бичиг хэрэг	1,108,500.00	12,660,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,763,200.00	2,017,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,200.00	804,100.00
210404	Ном, хэвлэл	73,600.00	430,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	815,900.00	2,052,930.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	30,360,000.00
210502	Хоол, хүнс	0.00	30,360,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	720,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	720,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,040,000.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	3,040,000.00	600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	158,000.00	22,183,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,000.00	22,150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,566,362,550.00	516,147,379.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,178,400.00	42,315,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,564,184,150.00	473,831,579.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8,004,676,164.00</b>	<b>6,571,555,056.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,556,080,338.00	6,372,534,230.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,710,100,338.00	1,582,041,230.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,845,680,000.00	4,032,378,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	758,115,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	448,595,826.00	199,020,826.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	420,158,480.00	180,736,426.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	28,437,346.00	18,284,400.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.00	0.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b><u>10,259,089,458.00</u></b>	<b><u>8,082,380,304.00</u></b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>40,157,578.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,157,578.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	40,157,578.00	0.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,157,578.00	0.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>40,157,578.00</b>	<b>0.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-40,157,578.00</u></b>	<b><u>0.00</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>12200</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	6,732,556,700.00	6,551,820,274.00
122005	Төсвөөс санхүүжих	6,732,556,700.00	6,551,820,274.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	6,732,556,700.00	6,551,820,274.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,988,949,300.00	6,551,820,274.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	976,880,400.00	937,401,044.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	799,467,900.00	771,461,097.00
210101	Үндсэн цалин	423,070,800.00	389,896,993.00
210102	Нэмэгдэл	304,309,200.00	277,059,900.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,455,300.00	54,487,727.00
210104	Урамшуулал	38,632,600.00	50,016,476.84
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	106,500,700.00	103,250,700.00
210201	Тэтгэврийн даатгал	73,460,400.00	70,210,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,260,100.00	8,260,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,130,100.00	4,130,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,130,100.00	4,130,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,520,000.00	16,520,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,563,200.00	25,998,842.00
210301	Гэрэл, цахилгаан	4,829,700.00	4,113,872.00
210302	Түлш, халаалт	16,823,600.00	15,623,600.00
210303	Цэвэр, бохир ус	5,909,900.00	6,261,370.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,997,600.00	7,504,930.00
210401	Бичиг хэрэг	2,496,200.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,672,000.00	2,017,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	813,100.00	804,100.00
210404	Ном, хэвлэл	430,000.00	430,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	430,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,156,300.00	2,052,930.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	720,000.00	720,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	720,000.00	720,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	600,000.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	600,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	18,168,300.00	16,033,000.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	16,000,100.00	16,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,343,800.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	442,600.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	224,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	157,800.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,862,700.00	11,832,475.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,977,000.00	3,977,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,885,700.00	7,855,475.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,012,068,900.00	5,614,419,230.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,012,068,900.00	5,614,419,230.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,674,561,500.00	1,582,041,230.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,337,507,400.00	4,032,378,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	6,988,949,300.00	6,551,820,274.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 295,467.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,829.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа <sup>1</sup> -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Олимпиадын зардлыг урьдчилж гарсан зардлаар гаргасан 1,429,000 төгрөгийг бүртгээгүй
- Багшийн алдар тэмдэг 2,400,000 төгрөгийн өртөгтэйг зарлагадаагүй

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 291,638.5 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 291,638.5 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,241.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

**3.1.1** Тайлант онд байгууллагын удирдлага нь санхүүгийн ажилтнуудын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан тушаал шийдвэргүй 1,241.7 мянган төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

## 3.2 Албан шаардлага

### 3.2.1 Ур чадвар, үр дүнгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт ур чадвар, үр дүнгийн нэмэгдлийг холбогдох үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэхгүйгээр мөнгөн урамшууллыг хавтгайруулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” , Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

## 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.3.1 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олголттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг журамд заасан хугацаа болоогүй байхад 31 албан хаагчдад 265,122.0 мянган төгрөг олгосон зөрчил илэрсэн нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 2-д тэтгэмжид тавигдах шаардлагад багш, ажилтан төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж (цаашид "сургалтын байгууллага" гэх)-д томилогдсон өдрөөс хойш тасралтгүй таван

жил (60 сар) болон дараагийн гурав дахь жил (36 сар) ажилласан байна гэсэнтэй нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг журамд заасан хугацааг баримтлан олгох, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх

### 3.3.2 Анхан шатны баримтын иж бүрдэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдсэн сургалтын цай хоолны зардал, бага хурлын зардлуудыг нярвын дансаар дамжуулан зарцуулсан гүйлгээнүүдийн анхан шатны баримт дутуу тооцоо бодсон акт байхгүй, төсөв төлөвлөгөө байхгүй, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг үнэлээгүй 25,274.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, нярвын дансаар дамжуулсан гүйлгээнүүдийн зарцуулалтын тайланг баримтад хавсаргах, сургалтын цай хоолны ирцийн бүртгэл, зурган тайланг хавсаргаж хэвших алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							тоо	Дүн	тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Олимпиадын зардлыг урьдчилж гарсан зардлаар гаргасан ч бүртгээгүй	1	1429.0			1	1,429.00	1	1429.0				
Багшийн алдар тэмдгийг зарлагдаагүй	1	2400.0	1	2400.0			1	2400.0				
	<b>2</b>	<b>3,829.0</b>	<b>1</b>	<b>2,400.0</b>	<b>1.0</b>	<b>1,429.0</b>	<b>2</b>	<b>3,829.0</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн журамд заасан хугацааг баримтлаагүй	1	265,122.0					1	265,122.0		
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжигдсэн сургалтуудын төсөв төлөвлөгөө, тайлан байхгүй, санхүүгийн баримтын иж бүрдэл хангалтгүй	1	25,274.8					1	25,274.80		
Ур чадвар, үр дүнгийн нэмэгдлийг холбогдох үнэлгээ, шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэхгүйгээр хавтгайруулан олгосон	1	-			1	-				
Балансын урамшуулал, үр дүнгийн нэмэгдлийг давхардуулан олгосон	1	1,241.7	1	1,241.7						
<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>291,638.5</b>	<b>1</b>	<b>1241.7</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>290,396.80</b>	<b>0</b>	<b>0</b>

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		